

**2019 ОНООС ЭХЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗАХИАЛГАТ ТӨСЛИЙГ
ДАРААХЬ ЧИГЛЭЛҮҮДЭЭР ЗАРЛАЖ БАЙНА.**

№	Төслийн нэр, хэрэгжих хугацаа	Үр дүнгийн даалгавар
Байгаль орчин, аялал жуулчлалын яам		
1.	Халиун бугын тархац, нөөц, зохистой ашиглах хэмжээг тогтоох, хамгааллын статусыг тодорхойлох 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол орны халиун бугын тархац, нөөцийг аймаг, агнуурын бүс, нутаг бүрээр тогтоох; - Тусгай зориулалтаар агнах халиун бугын тоо хэмжээг бүс нутаг бүрээр тооцох, байрлал зүйн зураглал, коридор нутгийн зураглал үйлдэх; - Монгол орны халиун бугын тархац, нөөц, сүргийн бүтцийн тухай мэдээлэл бүхий мэдээллийн сан бүрдүүлэх; - Монгол орны халиун бугын хамгааллын статусыг тодорхойлох;
2.	Загасыг зориудын аргаар үржүүлэн байгалийн нөөцийг нөхөн сэргээх 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Загас үржүүлгийн цехэд үржүүлсэн бие даан амьдрах чадвартай жараахайд үнэлгээ тогтоож, гол, нуурыг загасжуулах туршилтын ажлыг гүйцэтгэх; - Загасыг нөхөн сэргээх, экологи, эдийн засгийн үнэлгээ хийх; - Хөвсгөл аймгийн Доод цагаан нуур, Дорнод аймгийн Буйр нуурыг суурь үзүүлэлт болгон загасыг зориудаар үржүүлэх арга техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; - Загасны нөөц, усан орчны биологийн нөөцөд учруулсан хохирлыг үнэлэх аргачлал боловсруулах;
3.	Монгол орны доод ургамлын (замаг, мөөг, хаг, хөвд) хамгааллын статусыг тодорхойлох 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол орны замаг, мөөг, хаг, хөвдийн таксоны төрөл зүйл тус бүрээр “нэн ховор”, “ховор” статустай доод ургамлын зүйл бүрийг үнэлж, эрсдлийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох; тэдгээрийг хамгааллын статус ДБХХ-ны зүйлийн мэнд үлдэлтийн комиссын улаан дансны зэрэглэлийн арван түвшний шалгуураар үнэлж ангилах; - Устаж байгаа, устаж болзошгүй, эмзэг зэрэглэлд багтах зүйлүүдийн үндсэн шинжийг тодорхойлох, ховордлын шалтгааныг тогтоох, хамгаалах заавар, зөвлөмж боловсруулах; - Монгол орны 500 гаруй зүйл хөвд, 1030 зүйл хаг, 3000 орчим зүйл замаг, 800 зүйл дээд мөөгний хамгааллын үнэлгээ, статусыг тодорхой болгох, болзошгүй аюулаас сэргийлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах арга боловсруулах;

Сангийн яам		
4.	Уул уурхай олборлох үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг боловсруулах 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодох бүртгэлд тулгамдаж байгаа ил болон далд уурхайн хөрс хуулалтын зардлыг бүртгэх; - Капиталчлагдах болон үл капиталчлагдах зардлыг ангилах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн сан байгуулах; - Бүтээгдэхүүний нэгжийн өртгийг тооцох, борлуулалтын орлогыг бүртгэх арга зүйг тодорхойлсон байх;
Хууль зүй, дотоод хэргийн яам		
5.	Оюуны өмчийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшүүлэх 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Оюуны өмчийн үнэлгээний дэлхий нийтийн чиг хандлага, арга зүй, практик судалгаа; - Оюуны өмчийг үнэлэх үнэлгээний аргачлал, арга зүй боловсруулах; - Үнэлгээний болон бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх олон улсын шилдэг туршлага, арга, зарчмыг судлах, зөвлөмж гаргах;
6.	Хоригдолд олгох боловсролын хөтөлбөр: эрх зүйн зохицуулалт арга зүй 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Хоригдолд олгодог уламжлалт боловсрол, түүхэн замналын судалгаа; - Хоригдлын боловсролын эрх зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдлын судалгаа; - Хоригдолд зориулсан боловсрол, хөтөлбөрийн олон улсын шилдэг туршлага, арга зарчмыг судлах; - Хоригдлын бичиг үсгийн боловсрол, бүрэн дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, амьдрах ухааны боловсрол гэсэн 4 хөтөлбөр боловсруулах;
7.	Хэргийн газарт ашиглах явуулын лабораторийг бүтээх технологийн судалгаа, туршилт үйлдвэрлэл 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол Улс дахь хэргийн газрын үзлэгийн чанар, ашиглаж буй техник хэрэгсэл, явуулын лабораторийн ашиглалт, үр дүн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох; - Явуулын лабораторийн иж бүрдлийг зохион бүтээх, угсрах, туршилтаар үйлдвэрлэх, үр дүнг тооцох;
8.	Тогтвортой хөгжлийн бодлого ба Үндсэн хуулийн үзэл баримтлалын хэрэгжилт, үр дүн 2019	<ul style="list-style-type: none"> - Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын судалгаа; - 1992 оны Үндсэн хуулийн эх бичвэр болон Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад дүн шинжилгээ хийх; - Тогтвортой хөгжил, тогтвортой засаглалын шинжлэх ухааны үндэслэл;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам		
9.	Монгол Улсад суурь тэтгэврийг нэвтрүүлэх боломж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, загвар боловсруулах 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны өнөөгийн бодит байдалд үнэлгээ, дүгнэлт хийх; - Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жилээс жилд нэмэгдэж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох, сангийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр актуар тооцоолол, судалгаа хийж, санал боловсруулах; - Тэтгэврийн даатгалын тогтолцооны олон улсын шилдэг туршлагын арга зарчмыг судалж, Монгол Улсын тэтгэврийн тогтолцоог төгөлдөржүүлэх бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг тодорхойлох; - Монгол Улсад нэвтрүүлж болохуйц суурь тэтгэврийн даатгалын загварыг тодорхойлох /суурь тэтгэврийн даатгалд хамрах хүрээ, шимтгэл ногдуулах цалин хөлс, орлого, шимтгэлийн хувь хэмжээ, суурь тэтгэврийн сард олгох хэмжээ, суурь тэтгэврийн зарлага, хэтийн хандлага, тооцоолол зэргийг багтаасан загварыг боловсруулах/; - Монгол Улсад суурь тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлснээр тэтгэврийн сан болон иргэдийн тэтгэвэрт нөлөөлөх нөлөөллийн хэтийн актуар тооцоолол хийсэн байх;
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам		
10.	Газарзүйн мэдээллийн санд суурилсан цахим удирдлагын системийг соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын стратегид нэвтрүүлэх нь 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Цахим удирдлагын системийн бодлогын даалгаврыг боловсруулах, программ хангамж боловсруулах; - Мэдээллийг бэлтгэх, оруулах заавар, зааварчилгаа; - Цахим удирдлагын системийг турших, ашиглах; - Цахим удирдлагын системийн удирдлага, хэрэглэгчийг оновчтой тогтоох;
11.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үндэсний судалгаа 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зураглал гаргах /хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, нас, хүйсийн бүтэц, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, онош/; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын байдал /бичиг үсгийн мэдлэг, амьдрах ухаан, сургууль болон мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, боловсролын түвшин, ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцдаг эсэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургууль завсардалт, хүүхдийн хөгжлийн төв, гэгээрлийн төвд хамрагдсан байдал/;

		<ul style="list-style-type: none"> - Ажил эрхлэлт, гэр бүл, эрүүл мэндийн байдал; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгаа; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийн хэлбэрүүдийг тодорхойлох; - Зөвлөн тусалдаг, хамт ажилладаг хүмүүс, байгууллагын судалгаа; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, хөгжил, хамгаалал, хүмүүжил, төлөвшлийн талаарх мэдээлэл авч буй байдал, хэрэглээ; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэглэж буй сурах бичиг, техник хэрэгслийн судалгаа; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн авьяас, гаргасан амжилтын судалгаа;
12.	Хорин нэгдүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамжийн үнэлгээг боловсролын түвшингээр тогтоох нь 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Хорин нэгдүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшин бүрт үнэлэн тодорхойлох арга, аргачлалыг боловсруулах /сургуулийн өмнөх насны хүүхэд, бага, суурь, бүрэн дунд боловсролын суралцагч, дээд боловсролтой бакалавр /; - Монгол суралцагчийн боловсролын түвшин бүрт эзэмших цогц чадамжийг насны үечлэл, тодорхой судлагдахуун, мэргэжлийн хөтөлбөрт суурилан гаргах;
13.	Нүүдлийн соёл, орчин үеийн чиг хандлага хосолсон хувцас загвар зохион бүтээхэд малын гаралтай түүхий эдийг ашиглах нь 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Малын гаралтай түүхий эдийг ашиглан Монгол хувцас загварын коллекц зохион бүтээх /нүүдлийн соёлыг дэлхийн зах зээлд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хувцас загвар/; - Орчин үеийн загварын чиг хандлага, дизайны шийдлийг ашиглан олон улсад өрсөлдөх чадвар бүхий цоо шинэ хувцас загварын брэнд бий болгох;
14.	Монгол Улсын боловсролын бодлого, хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх арга, бодлогын судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх загвар боловсруулах 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Боловсролын бодлого, төсөл хөтөлбөрийн өртгийн үр дүн, өртгийн үр ашгийн үнэлгээ хийх загвар, аргачлал боловсруулах; - Боловсролын салбарт хэрэгжүүлж буй туршилтын төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийх чанарын болон тоон аргачлал боловсруулах; - Үндэсний хэмжээнд нэвтрүүлсэн боловсролын бодлого, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөөг хэмжих, дүн шинжилгээ хийх, хагас туршилтын панель судалгааны арга зүй, стандарт, гарын авлага боловсруулсан байх;

15.	Монгол төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах арга 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол Төрийн соёл, урлагийн салбарын уламжлалт бодлогын үндэс, үнэт зүйлийг судлан тодруулах; - Төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг олон улсын аргачлалаар үнэлэх, үнэлгээний шалгуур үзүүлэлт, арга зүй, аргачлал боловсруулах; - Төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн мастер төлөвлөгөө болон стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй;
16.	Багшийг хөгжүүлэх олон сонголтот онлайн сургалтын хөтөлбөр, хэрэгжилт, үр дүн 2019	<ul style="list-style-type: none"> - Мэргэжил дээшлүүлэх олон улсын сайн туршлага судлах, өөрийн оны нөхцөлд тохирсон сургалтын загвар боловсруулах; - Онлайн сургалтын олон сонголтот хөтөлбөр боловсруулах; - Олон сонголтот хөтөлбөрийн хөгжүүлэлт, live системийн өргөтгөлийн техникийн шийдэл, тодорхойлолтыг боловсруулах; - Онлайн видео хичээл, хэлэлцүүлэг, хурал зэргийг шууд live зохион байгуулах туршилт, зүгшрүүлэлт; - Эрдэмтэн судлаач, багш нарын илтгэл, хичээлийн сан бүрдүүлсэн байх;
Зам, тээврийн хөгжлийн яам		
17.	Монгол орны цаг уурын бүс бүрт тохирох битумын хэрэглээг тодорхойлох судалгаа 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол орны зам цаг уурын бүс бүрийн замын хучилтад тохирох битумын ашиглалтын үзүүлэлтийг нарийвчлан боловсруулах; - Манай орны цаг уурын тухайн бүсэд тохирох битумын физик, механик үзүүлэлтийг тодорхойлох; - PG ангиллын битумын стандарт боловсруулах, батлуулах;
18.	Төмөр замын суурь бүтцийн үнэ бүрдлийн системийг судалгаанд үндэслэн оновчтой тодорхойлох нь 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Төмөр замын замын дээд болон доод бүтэц, хиймэл байгууламжийн ажлын зураг; - Төмөр замын замын дээд болон доод бүтэц, хиймэл байгууламжийн төсвийг зохиох (үүнд төмөр зам баригдах бүс нутгийн онцлогоос хамааралтай нэмэлт зардлыг тооцох, түр барилга, түр замын ажлын) аргачлал; - Төмөр замын замын дээд болон доод бүтэц, хиймэл байгууламжийн ажлын зургийг зурах програм хангамж; - Төмөр замын замын дээд болон доод бүтэц, хиймэл байгууламжийн төсвийг норм нормативын дагуу бодох программ хангамж; - Төмөр замын замын дээд болон доод бүтэц, хиймэл байгууламжийг ажлын зургийн дагуу шинээр барьж ашиглах зарчим, аргачлал

		бүхий техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулах, батлуулах;
Засгийн газрын хэрэг эрхлэх газар		
19.	Дэлхийн өв: Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг"-ийн орчны бүсийн түүх, соёлын өвийн судалгаа 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Дэлхийн соёлын өвийн дурсгалт газар түүний орчны бүс нутагт эрдэм шинжилгээний экспедиц ажиллуулж, түүх соёлын өвийг бүртгэх, олон улсын стандартад нийцсэн бүртгэл мэдээллийн сан бий болгох ; - Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар түүний орчны бүс болон Дэлхийн өвийн бүс нутгийн газар усны нэрийн судалгаа; - Их Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг түүний орчны бүсэд хамаарах дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтанд бүртгэгдсэн дурсгалт газруудын танилцуулгыг дэвшилтэт технологи ашиглан олон улсын жишигт нийцүүлэн бэлтгэх; - “Дэлхийн соёлын өв: ”Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-ийн түүх, соёлын болон байгалийн өвийн судалгаа;
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		
20.	Монгол орны стратиграфийн нэгдсэн /хроно- биолито-/ ангилал боловсруулж геологийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Геологийн систем тус бүрийн стейжүүдийг төлөөлөх зүсэлтүүдийн судалгаа гаргаж, мэдээллийг нэгтгэх, зүсэлтийг нарийвчлан судлах; - Хроно-био-литостратиграфийн харьцуулалтыг тусгасан судалгааны материалыг систем тус бүрээр эмхэтгэн боловсруулж, геологийн үйлдвэрлэлд шилжүүлэх; - Монгол орны стратиграфийн нэгдсэн ангиллыг олон улсын шатлалтай харьцуулан судлах;
21.	Нуурын бүсийн палеозойн магматизм, геодинамик хөгжил, ашигт малтмал 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Нуурын бүсэд тархсан палеозойн насны магмын чулуулгийн нарийвчилсан геохими, геохронологийн судалгаа хийх; - Үнэмлэхүй нас, геохимийн шинж чанарт тулгуурлан магмын бүрдлүүдийн ангиллыг нарийвчлах; - Нуурын бүсийн палеозойн магматизмын

		<p>хөгжсөн геодинамикийн нөхцөлийг тодорхойлох;</p> <ul style="list-style-type: none"> - Палеогеодинамик орчинд хүдэржилтийн онцлогийг судлан, хэтийн төлөвийг тодорхойлох;
22.	<p>Монгол орны зүүн бүсийн холимог металлын хүдрээс бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн судалгаа, бүтээгдэхүүний стандарт боловсруулах 2019-2020</p>	<ul style="list-style-type: none"> - Нөөц нь тогтоогдсон, сонгосон орд газруудын холимог металлын хүдрийн сорьцод судалгаа шинжилгээг хийж гарсан үр дүнгээр холимог металлын хүдрийг олон улсын нэгдсэн зэрэглэл тогтоож, 6 ангилалд иж бүрэн хамруулах; - Монгол орны цайр, хар тугалгын хэрэглээг үндэсний үйлдвэрлэлээр хангах стратегийн хувилбар схемүүдийг боловсруулж, холбогдох тооцоо дүгнэлт хийж зөвлөмж гаргах; - Холимог металлын хүдрийг флотацийн аргаар баяжуулах, сайн чанарын баяжмал гарган авах, холимог металлын хүдрээс гарган авсан чанарын баяжмалыг орчин үеийн ангижруулах технологээр боловсруулж металлургийн үйлдвэрийн бүтээц гарган авах; - Холимог металлын хүдрийн олон улсын ангиллын стандарт, хар тугалга, цайрын хүдрийг хайлуулалтад бэлтгэх баяжмалын стандарт боловсруулах;
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		
23.	<p>Үхэр, сарлагийн өндгөн эсийг гадна орчинд өсгөвөрлөх, үр тогтоох, шилжүүлэн суулгах технологи 2019-2021</p>	<ul style="list-style-type: none"> - Өндгөн эс өсгөвөрлөх, үр тогтоох, гүн хөлдөөх үнэлэх, шилжүүлэн суулгах технологи; - Биеийн гадна гаргаж авсан хөврөлийн амилалт 60 хувиас доошгүй, хээл тогтолт 50 хувиас багагүй байх технологи; - Био технологийн аргаар гаргасан төлийн (хөврөл үр шилжүүлэн суулгаж гаргаж авсан сарлагийн төл 15 , махны чиглэлийн үхрийн төл 20, сүүний чиглэлийн үхрийн төл 20-оос доошгүй толгой) үндсэн ашиг шимийн үзүүлэлтүүд тухайн үүлдрийн стандартаас 15 хувиас илүү байх; - Сарлагийн гүн хөлдөөсөн 200, махны болон сүүний чиглэлийн үхэр тус бүрийн 200-аас доошгүй хөврөлийг Малын удмын сангийн төвд шилжүүлэх;
24.	<p>Махны чиглэлийн үхэрт зориулж, эх орны түүхий эдээр баяжуулсан шинэ төрлийн тэжээл үйлдвэрлэх технологи</p>	<ul style="list-style-type: none"> - Уламжлалт болон бусад төрлийн түүхий эдийг ашиглан махны үхэрт зориулсан тэжээл бэлтгэх 3-аас доошгүй технологи боловсруулах; - Үржлийн өсвөр үхэр өсгөн бойжуулахад зориулсан тэжээлийн 4 шинэ жор

	2019-2021	<p>боловсруулан турших;</p> <ul style="list-style-type: none"> - Махны үхрийг бордох 3-4 төрлийн тэжээлийн жор боловсруулах, турших; - Шинэ төрлийн тэжээл үйлдвэрлэл;
25.	Малын арьс, ширийг биологийн гаралтай гэмтлээс хамгаалах, сэргийлэх арга боловсруулах 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Үхэр, хонь, ямааны арьс, ширний биологийн гэмтлийн шалтгаан, зэрэглэл тогтоох; - Биологийн гэмтэл үүсгэж байгаа малын паразиттах өвчний нэр, төрөл, халдварын эрчимжил, хүрээ, идэвхжилтийг тогтоох; - Үхрийн гуур, хонь, ямааны хамуу, хачиг, ширх зэрэг өвчнүүдээс сэргийлэх зорилгоор эх орны эмийн бэлдмэлүүдийг сорилт туршилтаар харьцуулан судалж баталгаажуулах; - Өвөл, хаврын улиралд малын хашаа, саравч, хороог хашааны хачиг, хүрд, ширх зэрэг шимэгчдээс сэргийлэх, устгах бэлдмэлийн технологи боловсруулах; - Дээрх судалгааны үр дүнд үндэслэн эм бэлдмэлийн зөв сонголт, хэрэглээний оновчтой цаг хугацааг тодорхойлж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, арьс ширний чанарыг сайжруулах арга боловсруулах;
26.	Тариалангийн газрын чадавхи нөөцийн үнэлгээ тогтоох, түүнийг цаашид ашиглах үндэслэл боловсруулах 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Газар тариалангийн төв бүсэд таримлын ургацад гол нөлөө үзүүлж буй уур амьсгалын өөрчлөлт, газрын гадарга, хөрс, газар зүйн нөхцөл, хөрсний үржил шим, элэгдэл эвдрэл, бүс нутгийн био уур амьсгалын чадавхийн талаар байгаль орчны газар, ус цаг уур орчны шинжилгээний газар, хөдөө аж ахуйн газар, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, ургамал газар тариалангийн хүрээлэнд тус тусдаа салангид хийгдсэн судалгааны дүнг харьцуулан олон хүчин зүйлийг цогцоор үнэлж нэгдсэн дүгнэлт хийх замаар тариалангийн газрын чадавхи нөөцийг тогтоох; - Тариалангийн төв бүс нутагт шинээр атар эзэмших тохиромжтой газрыг шинэчлэн тогтоох; - Эзэмшил ашиглалтын талбай бүрийн чадавхийн үнэлгээг тогтоож, газар зүйн мэдээллийн системийн программ хангамжид суурилсан зурган мэдээлэл болон хөрсний төлөв байдал, үржил шим, элэгдэл эвдрэлийн мэдээллийн сан бүрдүүлэх; - Одоо байгаа эргэлтийн талбайнуудын чадавхийн үнэлгээнд үндэслэн DSSAT-4.0 загвараар ашиглалтын горим, өндөр ургац авах боломж нөхцөлийг тооцоолж зөвлөмж боловсруулах;

		<ul style="list-style-type: none"> - Атарших эрсдэлтэй газарт нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож, дахин ашиглах боломжийг судлах;
27.	Хүнс тэжээлийн шинэ таримлын сорт шалгаруулах, цөм үр бий болгох 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Хүнс, тэжээл, пивоны арвайн эх орны шинэ сорт бүтээж, шалгаруулан улсын сорт сорилтод дэвшүүлэх; - Хэрэглээний чиглэлээр ялгаатай арвайн нутагшсан сортуудын цөм үрийн нөөц бий болгох; - Газар тариалангийн бүсүүдэд ургах боломжтой хүнс, тэжээлийн эрдэнэ шишийн сорт шалгаруулах; - Тэжээлийн эрдэнэ шишийн эх орны сорт бүтээж улсын сорт сорилтод дэвшүүлэх; - Эрдэнэ шишийн эх орны сортын үр үржүүлэх, цөм үрийн нөөц бүрдүүлэх;
28.	Жимс, жимсгэний ургамал хамгаалах органик технологи боловсруулах 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Жимс жимсгэнэ, чацарганын талбайд тархаж буй өвчний зүйлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож, тэдгээртэй тэмцэх арга боловсруулах; - Жимс жимсгэнэ, чацарганын цэцэрлэгт зонхилон тархсан хөнөөлт шавьжийн зүйлийг тодорхойлж байгальд халгүй аргаар тэмцэх арга боловсруулах; - Жимс жимсгэнэ, чацарганын цэцэрлэгт зонхилон тархсан хөнөөлт мэрэгч амьтад болон шувуутай тэмцэх байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт аргыг турших;
29.	Органик мал аж ахуйд хэрэглэх байгалийн гаралтай шинэ эм, бэлдмэлийн технологи 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Органик аж ахуйн саалийн үүлдрийн үнээний физиологийн хэвийн үзүүлэлтүүдийг хангах, нөхөн үржихүйн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх 2-3 шинэ бэлдмэлийн технологи; - Саалийн үүлдрийн үнээний дэлэнгийн үрэвслээс сэргийлэх, эмчлэх антибиотикийн бус бэлдмэлийн технологи; - Эрчимжсэн болон шилжилтийн үеийн аж ахуйгаас нийлүүлж байгаа мах, сүүнд дааврын үлдэгдлийг тодорхойлох арга;
30.	Мал, амьтны гоц халдварт /шүлхий, цэцэг/ өвчний дэгдэлтэд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судлан, хариу арга хэмжээний оновчтой арга боловсруулах 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Гоц халдварт өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ; - Гоц халдварт өвчний дэгдэлтийн үед хэрэгжүүлэх мал эмнэлгийн өвөрмөц арга хэмжээний стандарт ажиллагааны заавар боловсруулах; - Химийн болон нийлэг гаралтай үйлчлэгч бодис агуулсан ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэлийн 1-2 хувилбар технологи боловсруулах; - Сонгон авсан бэлдмэлүүдийг хасах 30 хэм хүртэл in vitro орчинд, байгалийн хасах хэмд

		in vivo орчинд сорилт туршилт хийх, хэрэглэх арга /3/ боловсруулах;
31.	Мал эмнэлгийн зориулалттай эмийн хэрэглээний болон эмчилгээний эдийн засгийн үр ашгийг үнэлэх цогц арга боловсруулах 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Мал, амьтны шүлхий, боом, төлийн ходоод, гэдэс, амьсгалын замын болон гадна паразиттах өвчний эмчилгээний зардлын шинжилгээ; - Вакцинжуулалт, угаалга, туулгалт болон ариутгал, халдваргүйтгэлийн эмийн зардлыг бууруулах шинжилгээ; - Вакцин, антибиотик, ийлдэс болон шингэн нөхөх бэлдмэлийн зардал-үр дүнгийн шинжилгээ; - Малын 3 төрлийн /вакцин, антибиотик, өргөн хэрэглээний эм/ эмийн зарлага-ашгийн шинжилгээ; - Малын 3 төрлийн /вакцин, ариутгалын болон халдваргүйтгэлийн бэлдмэл/ эмийн зардал-өгөөжийн шинжилгээ; - Дээрх аргуудыг нэвтрүүлэх аргачилсан заавруудыг боловсруулах; - Зарим өвчний үед мөрдөх эмийн эмчилгээний удирдамж /5/, малын эмийн үр ашигтай хэрэглээний гарын авлага, зөвлөмж;
32.	Тариалангийн талбай болон доройтсон бэлчээрийн хөрсийг сайжруулахад микоризаг ашиглах технологи боловсруулах 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Зарим таримал ургамал болон , бэлчээрийн зонхилох өвчин, хортны зүйлийн бүрэлдэхүүнийг генетикийн түвшинд тодорхойлох, хөнөөлт шавьжийн популяцийн динамик, тархалт, хөнөөлийн хэмжээг судлан тогтоох; - Тариалангийн талбай болон бэлчээрийн зонхилох өвчин, мэрэгч амьтан, хөнөөлт шавьжтай байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй дэвшилтэт аргаар тэмцэх технологи боловсруулах; - Доройтсон бэлчээр, тариалангийн хөрсийг микориза ашиглан сайжруулах боломжийг судалж, зөвлөмж боловсруулах;
33.	Мах бэлтгэлийн дагалдах түүхий эдийг боловсруулах, эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Малын дотор мах, дайвар түүхий эдийн гарцын судалгаа; - Цул дотор мах боловсруулан, эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөр болон дэвшилтэт технологийн харьцуулсан судалгаа; - Салслаг, үслэг дайвар түүхий эд боловсруулан, эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөр болон дэвшилтэт технологийн харьцуулсан судалгаа; - Дотор махны найрлага, шинж чанарын онцлогт үндэслэн боловсруулах оновчтой технологийн шийдэл;

		- Биологийн идэвхт нэгдэл /пептид/ гарган авах технологи, хэрэглэх арга;
34.	Арьс ширний бэлтгэлийн чанарын системийг боловсронгуй болгох судалгаа 2019-2021	- Арьс ширний түүхий эдийн бэлтгэл, зах зээл, гарал үүсэл, чанарын бүсчилсэн судалгаа хийх; - Түүхий эдийн бэлтгэлийн тордолтын цехийн технологи -3 боловсруулах; - Түүхий эд бэлтгэлийн үнэ тогтоох аргачлал, бэлтгэлийн стандарт-3 боловсруулах; - Түүхий эд бэлтгэлийн талаар баримтлах бодлогын зөвлөмж боловсруулах;
35.	Ухаалаг газар тариаланг хөгжүүлэх техник, технологи боловсруулах 2019-2020	- Газар тариалангийн технологийн үйлдэл, чанар, ургацын байдалд ухаалаг систем бүхий төхөөрөмж ашиглан үнэлэлт өгөх арга технологи боловсруулах; - Ухаалаг систем бүхий төхөөрөмжөөр талбайн мэдээлэл цуглуулах, үйл ажиллагааг хянах, зохион байгуулах туршилт хийх, цогц хэмжүүр нарийвчлалыг тогтоох; - Ухаалаг систем бүхий төхөөрөмжийн мэдээллийг боловсруулж, үр дүнг хэрэглэгчдэд шууд хүргэх программ хангамжийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, хэрэглээ болгох;
Эрүүл мэндийн яам		
36.	Зүрхний дутагдал өвчний оношилгоо, эмчилгээ, хяналтын цогц менежментийг хэрэгжүүлэх 2019-2020	- Зүрхний дутагдал өвчний эмнэл зүйн тархвар зүйн судалгаа, өртөг үр дүнгийн судалгааг хийх; - Зүрхний дутагдлын цочмог болон архаг үеийн эмчилгээний менежментийг боловсронгуй болгох хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүнг тооцох; - Монгол улсын хэмжээнд зүрхний дутагдлын эмнэлэгт суурилсан цахим бүртгэлийн тогтолцоо бий болгох; - Зүрхний дутагдлын эмчилгээний технологи; - Зүрхний дутагдлын гарын авлага, эмнэлзүйн заавар боловсруулах;
37.	Өсөлтгүй жирэмслэлт болон ураг, нярайн эдэд TORCH халдварыг илрүүлэх судалгаа 2019-2020	- Олон төрлийн халдвар үүсгэгчийг нэгэн зэрэг илрүүлэх мультиплекс полимеразын гинжин урвалын арга нэвтрүүлэх; - TORCH халдварын шинжилгээг 5000 эмэгтэй, 500 ураг нярайн дээжид хийж, мэдээллийн сан бүрдүүлэх; - Төрөлхийн халдварын шалтгаант амьгүй төрөлт, төрөлхийн хөгжлийн гажиг, нярайн эрт болон хожуу үеийн нас баралтын түвшинг бууруулах эмчилгээний технологи, эмчилгээний заавар боловсруулах; - Эмэгтэйчүүдийн дундах TORCH халдварын мэдлэгийг дээшлүүлэх арга, гарын авлага;
38.	Алло-цусны үүдэл эс шилжүүлэн суулгах	- Цусны хавдар болон цусны бусад эмгэгтэй реципентэд донороос цусны үүдэл эс

	эмчилгээний технологийг нэвтрүүлэх нь 2019-2020	шилжүүлэн суулгах эмчилгээний технологийг нэвтрүүлэх; <ul style="list-style-type: none"> - Үүдэл эс шилжүүлэн суулгах технологид зайлшгүй шаардлагатай донор болон реципентийн генийн тохироог эсийн түвшинд тодорхойлох технологийг нэвтрүүлэх; - Цусны үүдэл эс, чөмөг шилжүүлэн суулгах оношилгоо эмчилгээний технологийн загварыг бий болгох; - Цусны эмгэгийн донорын сан бий болгох;
39.	Үр хөврөлийн удамзүй оношилгоо ба эр бэлгийн эсийн хөгжлийн эхэн үеийг үр тогтоох эмчилгээнд ашиглах технологийг нэвтрүүлэх нь 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Төмсөгний дутмагшлын шалтгаант үргүйдлийн үед эр бэлгийн эсийг хөгжлийн эхэн үед үр тогтоох эмчилгээнд ашиглах эмнэл зүйн заавар боловсруулах; - Үр хөврөлийн удам зүйн оношилгоог нэвтрүүлэх; - Эмчилгээ, оношилгооны заавар боловсруулах;
40.	Хүүхдийн бөөрний мэс заслын тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн бөөрний дурангийн мэс заслын төрөл, тоог нэмэгдүүлэх; - Уламжлалт аргыг дурангийн мэс заслын аргатай харьцуулан судлах; - Хүүхдийн бөөр шээсний замын чулууг зайнаас эмчлэх технологийг эмнэл зүйн практикт нэвтрүүлэх; - Бөөр шээсний замын чулуу өвчнийг эрт үед илрүүлэх арга; - Хүүхдийн бөөрний мэс заслын эмчилгээ, оношилгооны заавар боловсруулах; - Бөөрний мэс заслын тусламж үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх;
41.	Аалзавч дорх цус харвалт болон гавал доторх аневризмийн молекул эпидемиологийн судалгаа 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Аалзавч дорх цус харвалт болон гавал доторх аневризмийг нөхцөлдүүлэгч удамзүйн хүчин зүйлийг /молекул биологийн оношилгоо/ тодорхойлох; - Аалзавч дорх цус харвалт болон гавал доторхи аневризмийн молекулын механизмыг тодорхойлох /уургийн болон нуклейн хүчлийн экспрессийн судалгаа/; - Аалзавч дорх цус харвалт болон гавал доторхи аневризмийн эмчилгээний шинэ технологи боловсруулах/мэс заслын уламжлалт эмчилгээг эмгэг жамын шинэ бүтээгдэхүүнтэй хавсран хэрэглэх/; - Эмчилгээ, оношилгооны заавар боловсруулах;
42.	Монгол орны хүн амын дундах бамбай булчирхайн өвчлөл, түүнд нөлөөлөх иод болон эрсдэлт хүчин зүйлсийг судлах нь	<ul style="list-style-type: none"> - Бамбайн булчирхайн эмгэгийн тархалтыг тодорхойлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх; - Иодын солилцооны өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох;

	2019-2021	<ul style="list-style-type: none"> - Нарийн зүүний хатгалтын аргыг Монгол оронд нутагшуулах; - Иммуногистохимийн аргаар бамбай булчирхайн хавдруудыг ялган оношлох аргыг нэвтрүүлэх; - Бамбайн эмгэгт нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, эмчилгээ, оношилгооны заавар боловсруулах;
43.	Монгол улсад тохиолдож буй тархины анхдагч хавдрын дархлаа оношилгоо, хяналт 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Монгол улсад тохиолдож буй тархины анхдагч хавдрын дархлаа оношилгоог боловсронгуй болгох; - Тархины анхдагч хавдрын эмчилгээ, оношилгооны заавар боловсруулах; - Тархины анхдагч хавдрын хяналтын аргачилсан зөвлөмж боловсруулах;
44.	Булчингийн чангарлын үеийн Ботулин токсин-А тарилга эмчилгээний үр дүн, эмнэлзүйн туршилт судалгаа 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Тархины саа өвчний үеийн булчин чангаралд ботулин токсин-А тарилга эмчилгээний үр дүнг тооцох; - Тархины саагийн булчин чангарлын менежментэд ботулин токсин-А тарилга эмчилгээ хийх заавар боловсруулах; - Тархины саагийн сэргээн засах эмчилгээний гарын авлага, зөвлөмж боловсруулах;
45.	Өвсөн гурван халууны найрлагын ходоод, улаан хоолойн хорт хавдрын эсрэг нөлөө 2019-2021	<ul style="list-style-type: none"> - Сибирь чөдөр өвс- <i>Atragene sibirica</i> L/, Мөлхөө холтсон цэцэг- <i>Ranunculus repens</i> L/, Бунгийн яргуй- <i>Pulsatilla Bungeana</i> L/ зэрэг ургамлын нийлмэл жорыг ходоод, улаан хоолойн хорт хавдрын эсийн өсгөвөрт хэрэглэж үр дүнг тооцох туршилт судалгаа; - Эмчилгээний зөвлөмж, гарын авлага, фармакопейн өгүүлэл боловсруулах;
Эрчим хүчний яам		
46.	Дулаан дамжуулах төвөөс хангагдах хэрэгцээний халуун усыг эрчим хүчний хоёрдогч нөөцөөр шийдэх боломжийн судалгаа 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Хэрэгцээний халуун усны ачаалал, хэрэглээ, горимын судалгаа; - Дулаан дамжуулах төвүүдийн дэргэдэх эрчим хүчний хоёрдох нөөцийг тодорхойлох; - Эрчим хүчний хоёрдогч нөөцийн параметрийг өсгөх боломжийн судалгаа;
47.	Тархмал нарны эрчим хүчний системийг Монгол оронд нутагшуулах технологийн судалгаа 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Хот, суурингийн айл өрхийн цахилгааны хэрэглээг нарны эрчим хүчээр хангах судалгаа; - Бие даасан тархмал нарны цахилгаан үүсгүүрийг цахилгаан хангамжид нэвтрүүлэх боломжийн судалгаа; - Төвлөрсөн цахилгаан сүлжээнд ажиллах тархмал нарны цахилгаан үүсгүүрийг ашиглах технологи;
Цөмийн энергийн комиссын ажлын алба		

48.	Монгол Улсын радоны эрсдэлтэй бүс нутгийн газрын зураг боловсруулах 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Монгол орны геологийн тогтоц, чулуулаг ба түүнд агуулагдах ураны хэмжээг тодорхойлох; - Монгол Улсын хөрсний бүтэц, найрлага, ураны агууламжийн хэмжээг тодорхойлох; - Тухайн бүс нутагт тархсан амьдралын хэв маяг, барилга байгууламжийн төрөл, ашиглагдсан барилгын материалын чанар, түүнд агуулагдах ураны хэмжээг тодорхойлох; - Дээрх мэдээлэл, шинж чанар дээр суурилсан радоны эрсдэлтэй бүс нутгийн газрын зураг боловсруулсан байх;
Үндэсний хөгжлийн газар		
49.	Эдийн засгийн системийн салбар хоорондын холбоосын математик шинжилгээ ба хэтийн төлвийн тооцооны хувилбарууд 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Итератив аргаар тэнцвэрт нийлүүлэлтийг тодорхойлох; - Шууд аргаар тэнцвэрт нийлүүлэлтийг тодорхойлох; - Тэнцвэрт үнийг тодорхойлох; - Салбар хоорондын холбоосын шинжилгээний цогц алгоритмыг боловсруулах; - Салбар хоорондын шинжилгээнд мэдлэгт тулгуурласан секторын эконометрик загварчлал гаргах; - Инноваци, мэдлэгийн сектор бүхий салбар хоорондын балансын матрицыг тооцох арга зүйг боловсруулах;
Онцгой байдлын ерөнхий газар		
50.	Улаанбаатар хот болон түүний орчмын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн идэвхжилтийн судалгаа 2019-2020	<ul style="list-style-type: none"> - Шинээр тогтоосон хагарлын дагуу геологи, геофизикийн нарийвчилсан судалгаа хийж байршлыг тогтоох; - Хагарлын дээр болсон сүүлийн хүчтэй газар хөдлөлтийн хугацаа, давталтын насыг тогтоох; - Сансрын зургийн тайлал, хээрийн ажлын үр дүнд тулгуурлан Улаанбаатар хот болон хот орчмын нутаг дэвсгэрт орших идэвхтэй хагарлын судалгаа хийж, зураглал гаргах; - Хээрийн болон нүүдлийн станцын судалгаагаар ажиглагдаж буй газар хөдлөлтийн идэвхжилтийн гүний болон орон зайн тархалтыг нарийвчлан тогтоох, үнэлгээ өгөх;

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ